



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Г Улаанбурханы өвчлөлийг таслан
зогсоох стратеги батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24.2, Засгийн газрын 2011 оны 108 тоот тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбурханы өвчлөлийг таслан зогсоох стратегийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.
2. Стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Төгсдэлгэр), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
3. Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр улсын төсөв болон төсөл, хөтөлбөрт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч байхыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндэмбэрэл), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Жаргалсайхан)-т даалгасугай.





Эрүүл мэндийн сайдын 2012 оны
2 дугаар сарын 16 өдрийн 37 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

Улаанбурханы өвчлөлийг таслан
зогсоох стратеги (2012-2015)

Нэг. Үндэслэл.

ДЭМБ-ын Европын бүс улаанбурханы өвчлөлийг таслан зогсоож, улмаар устгах зорилтыг 2005 оноос дэвшүүлсэн бөгөөд 2007-2009 онуудад 1 сая хүнд лабораториор батлагдсан улаанбурханы 1 тохиолдол бүртгэгдэж байсан боловч 2011 онд Европын 39 улсад улаанбурхан өвчний дэгдэлт гарсан байна.

ДЭМБ-ын Номхон далайн баруун бүс (НДББ)-ийн орнуудад 2011 онд улаанбурхан өвчний батлагдсан 21530 тохиолдол буюу 1 сая хүн амд 11.9 өвчлөл бүртгэгдсэн байна.

ДЭМБ-аас НДББ-ийн орнуудад 2012 он гэхэд “Улаанбурханы өвчлөлийг таслан зогсоох” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Монгол улсын хэмжээнд 1964-1992 онуудад жилд дунджаар 6320 улаанбурхан өвчний тохиолдол, 79 нас барагт бүртгэгддэг байсан. Анх 1973 онд Гэрхлаажуулалтын үндэсний товлолд улаанбурханы эсрэг вакцины 1 тунг, 1986 оноос 2 дахь тунг нэвтрүүлснээр өвчлөл 1986-1996 онуудад 1976-1986 оны өвчлөлтэй харьцуулбал 7,5 дахин буурчээ.

Гэвч 1990-2002 онуудад улаанбурхан өвчний 3 удаагийн дэгдэлт бүртгэгдэж 2001-2002 онд улаанбурхан өвчний 10 нас барагт бүртгэгдсэн бөгөөд 1994, 1996, 2000 онуудад 1-14 насны хүүхдэд улаанбурханы эсрэг нэмэлт дархлаажуулалтыг хийснээр дэгдэлтийг таслан зогсосон байна.

Ер нь манай улсад 1976-2003 онд бүртгэгдсэн улаанбурханы өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийхэд дэгдэлтийн үечлэл 4-5 жил байна.

Улсын хэмжээнд 2004, 2005, 2010 онд улаанбурханы өвчлөл бүртгэгдээгүй бөгөөд 2006-2009 онд улаанбурхан өвчний 75 тохиолдол бүртгэгдсний 36% нь 1 хүтэл насны, 19% нь 5-9 насны, 11% нь 10-14 насны хүүхэд байжээ.

Улаанбурханы үндэсний лаборатори нь улаанбурханы вирус ялгах шинжилгээг хийж, 2001-2002 онд бүртгэгдсэн улаанбурханы дэгдэлт нь H1, 2006 онд D6, 2009 онд H1 генотипийн вирус эргэлтэнд байсныг тогтоогоод байна.

Улаанбурхан, гахайн хавдар, улаанууд (УГУ)-ын хавсарсан вакциныг 2009 оноос дархлаажуултанд нэвтрүүлсэн бөгөөд уг вакцины 1 дүгээр тунгийн хамралт өндөр байгаа хэдий ч 2 дугаар тунгийн хамралт 95%-д хүрэхгүй байна.

ДЭМБ нийт хүн амын улаанбурханы эсрэг дархлааны түвшин 95 хувьд хүрсэн тохиолдолд улаанбурхан өвчнийг таслан зогсоох боломж бүрдэнэ гэж үздэг. Тэгвэл манай улсад 2004 онд 9 сартайгаас 60 хүртэлх насын хүн амын дунд хийсэн судалгаагаар 83.5% нь улаанбурхан өвчний эсрэг дархлаатай, 16.5% дархлаагүй байв (Тарилгатай халдварт өвчний эсрэг дархлал тогтцын түвшингийн судалгаа, 2004).

Уг судалгааны дунд үндэслэн 2007 онд 2-10 насын хүүхдүүдэд нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулсан нь дэгдэлтээс урьдчилан сэргийлсэн арга хэмжээ болсон юм.

Халдварт өвчний эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоо 2007 оноос нэвтэрч, улаанбурханы тандалтын мэдээг 7 хоног тутам авч, мэдээлэлд дун шинжилгээ хийж байна. Гэвч ДЭМБ-ын улаанбурханы тандалтын зарим шалгуур үзүүлэлт биелэхгүй байна. Тухайлбал, 2010 онд улаанбурхан өвчний онош үгүйсгэгдсэн сэжигтэй 1-ээс дээш тохиолдол бүртгэгдсэн аймаг, дүүргийн хувь 31,8%, сэжигтэй тохиолдлын тандалтын судалгааг хугацаанд нь бүрэн хийсэн хувь 65 байгаа нь 80%-иас дээш байх шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Иймээс дэлхийн олон улс оронд улаанбурханы дэгдэлт гарч байгаа өнөө үед НДББ-ийн зорилтыг хэрэгжүүлэх, УГУ-ын эсрэг вакцины бүрэн тунгийн хамралтыг нэмэгдүүлэх, хүн амын дархлааны түвшинг 95 хувьд хүргэх, улаанбурханы дэгдэлтийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай авах, лабораториид суурилсан тандалтыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

Улаанбурханы өвчлөлийг эрс бууруулан улмаар устгах.

Гучав. Стратегийн зорилт, хүлээгдэж байгаа үр дүн.

Стратегийн зорилт 1

Улаанбурханы эсрэг хүн амын дархлаа тогтоцын түвшинг 95-аас дээш хувьд хүргэх.

Хүлээгдэж буй үр дүн

1. УГУ-ны хавсарсан вакцины бүрэн тунгийн хамралт 95-аас дээш хувьд хүрсэн байна.

2 Зорилтот бүлгийн хүн амыг улаанбурханы эсрэг нэмэлт болон нөхөн дархлаажуулалтад бүрэн хамруулна.

3. Дархлаажуулалтын хамралтын нэгдсэн сүлжээг нэвтрүүлсэн байна.

4. Хүн амын дунд улаанбурханы эсрэг дархлааны түвшинг тодорхойлох ийлдэс судлалын шинжилгээг 2 жил тутам хийнэ.

Стратегийн зорилт 2

Халуунтай, тууралтат хам шинж, улаанбурхан өвчний тохиолдолд сууринсан тандалтыг эрчимжүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн:

1. Халуунтай, тууралтат хам шинж, улаанбурханы тандалт (ХТХШУТ)-ыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд нэвтрүүлнэ.

2. ДЭМБ-ын улаанбурхан болон улаанууд өвчний тандалтын шалгуур үзүүлэлтийг хангана.

3. Улаанбурхан өвчний тохиолдол бүрийг лабораториор баталгаажуулна.

4. Улаанбурханы өвчний эргэлтэд байгаа вирусын хэвшинжийг тодорхойлох замаар улаанбурханы халдварт зөөвөрлөгдөн ирсэн эсэхийг тогтоох лабораторийн чадавхтай болсон байна.

Гурав. Стратегийн хэрэгжилтийн зохион байгуулалт

Улаанбурханы өвчлөлийг таслан зогсоох үндэсний стратегийг 2012-2015 онд хэрэгжүүлнэ. Стратегийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, оролцогч байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үргийг Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ), орон нутагт

аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар (ЭМГ), Нийгмийн эрүүл мэндийн төв (НЭМТ) хүлээнэ.

Улаанбурханы өвчлөлийг таслан зогсоох үйл ажиллагааны төлөвлөгөөний санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийг дэмжих сан, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив тусlamж болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Дөрөв.Стратегийн хяналт- шинжилгээ, үнэлгээ

ЭМЯ-ны МХШҮГ нь стратегийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ хийх төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хянана.

5.2. Стратегийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	ДЭМБ-ЫН зорилт	2010 оны сурь	2012 он	2013 он	2014 он	2015 он
1.	Бүртгэгдсэн ХТХШ-ээс улаанбурхан өвчний онош үгүйсгэгдсэн тохиолдлын тоо /100.000 хүн амд /	2 %	5,9%	2%	2%	2%	1%
2.	Улаанбурхан өвчний онош үгүйсгэгдсэн сэжигтэй нэгээс дээш тохиолдол бүртгэгдсэн аймаг, дүүргийн хувь /100.000 хүн амд /	≥80%	31,8%	≥ 60%	≥ 70%	≥ 80%	≥ 80%
3.	Улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдлын тандалтын судалгааг хугацаанд нь бүрэн хийсэн хувь /мэдээлснээс хойш 48 цагийн дотор/	80%	65%	80%	80%	90%	90%
4.	Улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдлоос шаардлага хангасан цусны сорьц хугацаанд нь ирүүлсэн хувь /тууралт гарснаас хойш 14 хоногийн дотор/	80%	92,5%	95%	95%	95%	95%
5.	Лабораторид хүлээн авсан сорьцны хариуг 7 хоногийн дотор тандалтын нэгжид эргэн мэдээлэх хувь	80%	80%	85%	90%	95 %	95%

6.	Тандалтын 7 хоногийн мэдээг бүрэн өгсөн хувь		95%	$\geq 96\%$	$\geq 97\%$	$\geq 98\%$	$\geq 98\%$
7.	Тандалтын сарын мэдээг хугацаанд нь өгсөн хувь		95%	$\geq 96\%$	$\geq 97\%$	$\geq 98\%$	$\geq 99\%$
8.	Улаанбурхан өвчний сэжигтэй нийт тохиолдлоос эмнэлзүйгээр батлагдсан тохиолдлын эзлэх хувь	10%	0	$\leq 1\%$	$\leq 1\%$	$\leq 1\%$	$\leq 1\%$
9.	УГҮ-ын эсрэг вакцины 1 дүгээр тунгийн хамралтын хувь	95 %	96.5%	98%	98%	98%	98%
10.	УГҮ-ын эсрэг вакцины 2 дугаар тунгийн хамралтын хувь	95 %	94,0 %	$\geq 96\%$	$\geq 96\%$	$\geq 97\%$	$\geq 98\%$
11.	Улаанбурханы өвчлөлийн үзүүлэлт*	0.0	0.02**	0.0	0.0	0.0	0.0

Тайлбар: * 1 сая хүн тутамд улаанбурхан өвчний батлагдсан 1 тохиолдол
(зөөвөрлөгдөж ирсэн тохиолдлыг оролцуулахгүй).

**Сүүлийн 5 жилийн дундаж.

93

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
2 дугаар сарын 16. өдрийн 57 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

**Улаанбурханы өвчлөлийг таслан зогсоох стратегийн
үйл ажиллагааны төлөвлөгөө**

д/д	Үйл ажиллагаа	Хугацаа /оноор/	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Төсөв төгрөгөөр /Эх уусвэр/
Стратегийн зорилт 1: Улаанбурханы эсрэг хүн амын дархлаа тогтоцын түвшинг 95-аас дээш хувьд хүргэх.					
1.1	ҮГҮ-ын хавсарсан вакцин, зүү тариур, аюулгүй хайрцгаар аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудыг хэрэлтгүй хангах	2012-2015	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	90,000,0 /Засгийн газар/
1.2	ҮГҮ-ын хавсарсан вакцины хамралтыг бүрэн тунгаар /2-р тун/ гаргах	2012-2015	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	
1.3	ҮГҮ-ын дархлаажуулалтын хамралт, хамрагдвал зохих хүүхдийн тоог тооцох, үнэлгээ хийх аргачлал боловсруулах	2012	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	
1.4	ҮГҮ-ын хавсарсан вакцины бүрэн тунгийн хамралт 95 хувиас доош байгаа аймаг, дүүрэгт шалтгааныг тогтоох судалгаа хийх	2012-2015	ХӨСҮТ	Аймаг, Нийслэлийн ЭМГ,	5,000,0 /ВДГА/
1.5	ҮГҮ-ын дархлаажуулалтаас хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулах арга хэмжээг жилд 2 удаа зохион байгуулах	2012-2015	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, НҮБ-ын Хүүхдийн сан	10,000,0 /НҮБ-ын Хүүхдийн сан, ВДГА/
1.6	Улаанбурханы эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах	2012, 2015	ЭМЯ, ХӨСҮТ	НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ, Аймаг, нийслэлийн ЭМГ	100,000,0 /НҮБ-ын Хүүхдийн сан, ВДГА/
1.7	ҮГҮ-ын хавсарсан вакциныг тарих техник, вакцины хадгалалтын талаар сургалт зохион байгуулах	2012	ХӨСҮТ	ДЭМБ	10,000,0 /ВДГА/
1.8	Дархлаажуулалтын хамралтын нэгдсэн программ нэвтрүүлэх	2012-2013	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	30,000,0 /НҮБ-ын Хүүхдийн сан, ВДГА/
1.9	Программ хангамжийн гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах	2012	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	30,000,0 / ВДГА/
1.10	Хүүхдийг цэцэрлэг, ерөнхий	2013-2015	ХӨСҮТ	БСШУЯ	20,000,0

	боловсролын сургуульд элсэн ороход УГУ-ын вакцины бүрэн тунд хамрагдсан эсэхийг шалгаж, нөхөн дархлаажуулах тогтолцоог нэвтрүүлэх				/НҮБ-ын Хүүхдийн сан, ВДГА/
1.11	УГУ-ын дархлаажуулалт, ХТХШУ-ын тандалтын талаар цэцэрлэг, ЕБС сургуулийн багш, эмч нарт сургалт зохион байгуулах.	2012	ХӨСҮТ	БСШУЯ, Аймаг, нийслэлийн ЭМГ, Боловсролын газар	20,000,0 /ДЭМБ/
1.12	Вакцинатор сувилагч нарыг бэлтгэх сургалтын төлөвлөгөө гарган сургалт зохион байгуулах	2012-2015	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	30,000,0 /ДЭМБ, ВДГА/
1.13	Хүн амын дунд улаанбурханы эсрэг дархлалын түвшинг тодорхойлох ийлдэс судалалын шинжилгээ хийх	2013,2015	ХӨСҮТ	Аймаг дүүргийн ЭМГ, ЭМН	20,000,0 /ДЭМБ/
1.14	УГУ-ын дархлаажуулалтын хамралтын сар бүрийн мэдээнд дүн шинжилгээ хийж эргэн мэдээлэх	2012-2015	ХӨСҮТ	Аймаг дүүргийн ЭМГ, ЭМН	
1.16	УГУ-ын дархлаажуулалтын талаар мэдээлэл, сурталчилгааны материал боловсруулах, хэвлүүлэх	2012,2013	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	20,000,0 /НҮБ-ын Хүүхдийн сан, ВДГА/
Талын дүн					385,000,0

Стратегийн Зорилт 2: Халуунтай, тууралтат хам шинж, улаанбурхан өвчний тохиолдолд суурилсан тандалтыг эрчимжүүлэх

2.1	ХТХШУ-ны тандалтын журмыг шинэчлэх	2012	ХӨСҮТ	ЭМЯ, ДЭМБ	
2.2	ХТХШУ-ны тандалт, сэжигтэй тохиолдоос сорьц цуглуулах, сорьцыг дгалах, тээвэрлэх талаар эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан гарын авлага боловсруулах, хэвлүүлэх	2012	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	5,000,0 /ДЭМБ, ВДГА/
2.3	Цочмог сул саажилтын тандалтын мэдээтэй хамт ХТХШУ-ны тандалтын мэдээг 41 нэгжээс 7 хоног тутам авч нэгтгэх, хяналт хийх	2012-2015	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	
2.4	ХТХШУ-ны тандалтын явц, ДЭМБ-ын шалгуур үзүүлэлтийн талаарх эргэн мэдээллийг тогтмол хийх, сургалт зохион байгуулах	2012-2015	ХӨСҮТ	ДЭМБ, Аймаг, нийслэлийн ЭМГ	20,000,0 /ДЭМБ,
2.5	ДЭМБ-ын ХТХШУ-ны тандалтын шалгуур үзүүлэлтийг хангаагүй аймаг, дүүрэг, сум, өрхийн эмнэлэгт дэмжлэгт хяналт хийх, ажлын байран дээрх сургалт явуулах.	2012-2015	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	25,000,0 /ДЭМБ, ВДГА/
2.6	Улаанбурханы үндэсний лабораторийг шаардлагатай урвалж бодисоор хангах	2012-2015	ЭМЯ, ХӨСҮТ	ДЭМБ	5,000,0 /ДЭМБ/

2.7	ХТХШ-ийн үүсгэгчийг тодорхойлох лабораторийн оношуур, сорьцны саваар хангах.	2012-2015	ЭМЯ, ХӨСҮТ	ДЭМБ	10,000,0 /ДЭМБ/
2.8	Улаанбурханы ДЭМБ-ын бүсийн явлагaa лабораторид жил бүр улаанбурханы сорьц илгээж баталгаажуулах.	2012-2015	ХӨСҮТ	ДЭМБ	5,000,0 /ДЭМБ/
2.9	Үндэсний тандалтын болон лабораторийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, гадаадад сургалтад хамруулах.	2012-2015	ЭМЯ, ХӨСҮТ	ЭМЯ, ДЭМБ	10,000,0 /ДЭМБ/
2.10	Эргэлтэд байгаа улаанбурханы вирусын генотипийг тодорхойлох шинжилгээ хийх	2012-2015	ХӨСҮТ	ЭМЯ, ДЭМБ	5,000,0 /ДЭМБ/
	Талын дүн				85,000,0

Гурав. Стратегийн хяналт- шинжилгээ, үнэлгээ

3.1	Сонгосон аймаг, дүүргийн дархлаажуулалтын хамралтад чанарын үнэлгээ хийх.	2012, 2015	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	20,000,0 /ДЭМБ, ВДГА/
3.2	Сонгосон аймаг, дүүргийн дархлаажуулалтын үйл ажиллагаа, ХТХШУ-ны тандалтад хяналт, үнэлгээ хийх.	2013, 2015	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	10,000,0 /ДЭМБ, ВДГА/
3.3	Стратегийн хэрэгжилтэд явцын болон төгсгөлийн үнэлгээ хийх	2013, 2015	ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	10,000,0 /ДЭМБ, ВДГА/
	Талын дүн				40,000,0
	Бүгд				510,000,0